

**2020 ОНЫ АЙМАГ НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН
1 ДҮГЭЭР ТОЙРОГ НАРИЙН ГОЛ БАГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАЛСАН
ОВОГТОЙ ЭНХБАЯРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Олон ястны удам ажилч, хөдөлмөрч уламжлалтай Буянчуудтайгаа хамтран төрийн байгуулалт, эрх зүй, гадаад бодлого, эдийн засаг, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, биеийн тамир, спорт, аялал жуулчлал, үйлдвэрлэл, дэд бүтэц, барилга хот байгуулалт, хөдөө аж ахуй, ногоон хөгжлийн бодлогын чиглэлээр зорьсон зорилго, төлөвлөсөн ажлуудаа хийж хэрэгжүүлэн төрж өссөн сум орон нутгаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож, Ховд аймгийн Буянт сумын иргэн Балсан овогтой Энхбаяр миний бие **“Буянт сумынхаа хөгжил дэвшлийн төлөө санаачилна, хэрэгжүүлнэ, шинэчилнэ, өөрчилнэ, бүтээн байгуулна”** мөрийн хөтөлбөрөөр 2020 оны Орон нутгийн сонгуульд бие даан нэр дэвших шийдвэр гаргасан тул Та бүхэндээ толилуулж байна.


Орон нутгийн сонгуульд бие даан нэр дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, нийт Буянт нутгийн хөдөлмөрч хичээнгүй ард түмэнтэйгээ хамтарч хэрэгжүүлэх болно.

1. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙ, ГАДААД БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- Төсөвт албан байгууллагуудын нийт ажилтан, албан хаагчдыг хүнд сурталгүй сум орон нутаг ард иргэдээ гэсэн зөв хандлагатай, мэдлэг чадвартай, түргэн шуурхай, авлига, хээл хахуульгүй, тогтвор суурьшилтай, төвлөрсөн “чадамжтай, бүтээлч засаглал” бодлого хэрэгжүүлнэ.
- Төрийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, шилэн дансны тогтолцоог олон нийтэд ил тод хэрэгжүүлж ажиллана.
- Сумын удирдлагууд улирал тутамд үйл ажиллагааны тайлангаа иргэдэд нээлттэй тайлагнана.
- Ажлын байрны сонгон шалгаруулалтыг сул орон тоо гарах бүрт сум орон нутгийн боловсон хүчинг бэлтгэн боловсруулж ажиллуулах
- Гадаад харилцааг өргөжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлж хөрөнгө оруулалт, нийгэм соёлын олон талт харилцааг эрс сайжруулна
- Гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд зохион байгуулах.
- Иргэдэд ээлтэй сум, иргэдэд ээлтэй баг болох бодлого баримтална.
- Казакстан болон Тува улсуудтай сум орон нутгийн хамтарсан түншлэлийн харилцааг бий болгох ажлыг санаачилна.

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- Авлига, хээл хахууль хүнд сурталгүй жижиг бизнесийн салбарыг бий болгох ажлыг санаачилна.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийг олон нийтэд ил тод нээлттэй болгож жижиг дунд үйлдвэрлэлийг эрчимтэйгээр хөгжүүлэх тал дээр анхаарах.
- Буянт хөгжлийн сангийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон нийтэд ил тод болгох ажлыг санаачилна.
- Сум хөгжүүлэх сангийн болон бусад Тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод болгох.
- Ховд эко цемент үйлдвэрийн ажилчидын хүнсний мал, мах, сүү сүүн бүтээгдэхүүн хүнсний ногоог 100% Буянт сумаас нийлүүлэх ажлыг санаачлах.
- Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй хайгуулын компануудтай байгуулсан гэрээг шинэчлэн нягталж сум орон нутагт ашигтай, байгальд орчинд хор хөнөөлгүй, малчдын эрх ашиг хөндөхгүйгээр хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Буянтчуудын эрх ашигийг хамгаална.
- Түгээмэл тархацтай байгалын баялагийг эдийн засгийн эргэлтэнд оруулах идэвхи санаачлага гаргаж ажиллана.



3. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД

➤ Боловсрол, хүний хөгжил

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хуучин дотуур байр цэцэрлэгийн хуучин байруудад их засвар хийж үйлдвэр үйлчилгээний төв болгоно.
- Боловсролын салбарт төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.
- Багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ
- “Ном”, “Авьяас” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- “Багш хөгжлийн төв” байгуулна.
- “Чадварлаг багш”, “Чадварлаг сурагч” хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.
- Сурагчдын сурлагын чанарыг нэмэгдүүлнэ.
- Иргэн бүрийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөрийг дэмжин ажиллах.
- Багш нарыг мэргэжил дэшлүүлэх сургалтанд хамруулж дэмжих (магистр, доктор)
- Цэцэрлэгийн насны хүүхдүүдийг СӨБ-д бүрэн хамруулах.
- Хөдөөгийн багуудад гэр цэцэрлэгийг жилд 1-2 удаа тогтмол ажиллуулах.
- Оюутан залуучуудын боловсролыг дэмжих.

➤ Нийгмийн халамж, хамгаалал


- Ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тусгай эмнэлэгт эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай хүмүүсийн эмчилгээний зардалд зориулсан “тусгай зориулалтын” сан байгуулна.
- Бүтэн болон хагас өнчин хүүхдүүдэд жилд бүр дэмжлэг үзүүлнэ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг, нөхөн сэргээлт, тусгай сувилалын газарт жил бүр эмчлүүлэх
- Өрх толгойлсон, ажилгүй, орлогогүй иргэдийн нийгмийн асуудалд анхаарна.
- “ахмадын амралт чөлөөт цагт зориулсан танхим ” байгуулна.

➤ Эрүүл мэнд

- Сумын эмнэлгийг орчин үеийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгслээр хангана.
- Иргэдийг жил тутамд эмчийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн асуудалд анхаарч ажиллана.
- Эрүүл мэндийн сургалт, мэдээллийг цаг тухайд хүргэж иргэдийн эрүүл мэндэд анхаарах.
- Хөдөөгийн багуудын эмч нарын ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангах тал дээр туслалцаа үзүүлэх.
- Эрүүл мэндийн төвийн ажилчин, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Эрүүл мэндийн төвийн эмчилгээний болоод албан хэрэгцээний тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд санал санаачилга гаргана
- Эрүүл мэндийн төвийн гадна хашааг шинэчлэх
- Шүдний өвчлөлийг бууруулж эрүүл шүд хөтөлбөр хэрэгжүүлэх
- Эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч хөтөлбөр хэрэгжүүлэх
- Сумын хүн амыг өсгөх бодлого баримтлах
-

➤ Соёл урлаг

- Сумын музейн үзмэр өв соёлын эд зүйлийг цуглуулж тэнхим тохижуулна, номын санд номын баяжилт жил бүр хийх ажил санаачилна
- Угсаатны бүлгүүдийн урлаг, соёлыг өвлөн уламжлуулах зорилгоор урлаг, соёлын наадмуудыг зохион байгуулна.



[Handwritten signature]


- Ардын язгуур урлаг (хөөмий, тууль, цуур, уран нугаралт, бий биелгээ)–ийг гадаад, дотоодод сурталчлах, аялал жуулчлалыг татах арга хэмжээг төрийн болон хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Шинэ соёлын төвийн заал, өрөө танхимыг тохижуулна
- Сумын соёлын төвийг тасралтгүй үйл ажиллагаатай байлгах хүрээнд соёлын арга хэмжээг өргөжүүлж, идэвхжүүлнэ.
- Сумын соёлын төвийг 13 үндэстэн ястаны иж бүрэн язгуурын хувцастай болгох ажлыг зохион байгуулна
- Соёлын төвийн дэрэгдэх морин хуурийн дугуулинд хөдөөгийн хүүхэд залуучуудыг хичээллүүлж 200 морин хуурч хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Ардын дуу, уртын дуу, бий бийлгээ яруу найрагийн олон талт уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах ажлыг санаачилан хэрэгжүүлнэ
- Сумын номын санд Ганжуур Данжуур хөлгөн их судар залах ард нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна

➤ *Биеийн тамир, спорт, аялал жуулчлал*

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар спорт цогцолбор шинээр барих ажлыг санаачлах.
- Сумын хөдөөгийн багуудын дунд спортын олон төрөлт уралдаан, тэмцээнийг зохион байгуулна.
- Сумын баяр наадмыг бие даан зохион байгуулдаг болох тал дээр санал санаачлага оруулах.
- Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж “Хөдөлгөөн, эрүүл мэнд” аяныг тогтмол зохион байгуулах.
- Буянт сумын иргэдийн эрүүл амьдрах орчин бүрдүүлэх зорилгоор богино зайд явган болон дугуйн аяллын зам, маршрут бий болгож үе шаттай хөгжүүлнэ.
- Сумын төвд явган хүний замыг нэмэгдүүлнэ.
- Хар-Ус нуур, Ховд гол, Буянт голыг түшиглэсэн аялал жуулчлалын бичил баазуудыг бий болгох нөхцөл бүрдүүлнэ
- Шагай харваа, Сур харваа зэрэг үндэсний спортыг хөгжүүлэх.
- Уяачдын холбоо, бөхийн холбооны үйл ажиллагааг идэвхижүүлэн ажиллах.
- “Спортлог Буянтчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

4. ҮЙЛДВЭРЛЭЛ, ДЭД БҮТЭЦ, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД


- Сумын хилийн цэсийн маргааныг нэн тэргүүнд шийдвэрлүүлэх ажилд санал санаачлагатай ажиллах.
- Газар зохион байгуулалтын ажлыг цогцоор нь шийдвэрлэх ажлыг санаачилна.
- Багийн төвүүдийг цахилгаан эх үүсгэвэрт холбох ажлыг санаачилна.
- Төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлж ажиллах.
- Сумын төвийн авто зам, явган хүний замыг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж шийдвэрлүүлнэ.
- Арьс шир, ноос, нэхий боловсруулах, ногоо даршлах, тэжээл үйлдвэрлэх бичил үйлдвэр барьж байгуулах ажлыг санаачилна.
- Буянтын тарвас, улаан лооль, амтат гуа зэргийг бренд бүтээгдэхүүн болгож олон нийтэд сурталчилан таниулах ажлыг дэмжин ажиллах.
- Буянт сумын хогийн асуудлыг бүрэн шийдвэрлэж төвлөрсөн хогийн цэгийг шинэчлэж эко орчин бүрдүүлэх.
- Буянт сумын гэр хорооллын гудамжинд явган хүний зам тавьж, гэрэлтүүлгүүд нэмэх.
- Бүх баг алслагдсан нутгуудад утасны сүлжээ оруулах ажлыг шийдвэрлүүлэх
- Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөнө.
- Буянт суманд орчин үеийн шийдэл бүхий, эдийн засгийн хэмнэлттэй үнийн уян хатан сонголттой “Хаус хороолол”-ыг хувийн хэвшилтэй хамтарч олноор бий болгоно..
- Хуучны орон сууцнуудын гадаад өнгө үзэмжийг орчин үеийн шийдэлд оруулж сумын орчинг тохижуулж сайжруулах.



- Сумын төвд гэр бүл, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэг хүрээлэн, ногоон төгөл байгуулах ажлыг санаачилна.
- Нийтийн халуун ус, үсчин, оёдол, цахилгаан бараа засвар зэргийг бүрэн ажиллагаанд оруулж иргэдийн таатай амьдрах орчин нөхцлийг сайжруулахад анхаарч ажиллана.
- Сумын төвийн гэр хорооллын гудмуудыг ногоон байгууламж болгох.

5. ХӨДӨӨ АЖ АХУЙ, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- Эрчимжсэн мал аж ахуйг нэн тэргүүнд нутгийн иргэдийн оролцоотой бий болгох.
- Мал угаалгын ванн, мал тарилгын хашаа, мал эмнэлэгийн цогц үйлчилгээг хөдөөгийн таван багт дэвшилтэд түвшинд хэрэгжүүлэх ажлыг санаачлах.
- Залуу малчдыг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Малжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, эрүүлжүүлэхэд голлон анхаарна.
- Суманд цагаан идээ боловсруулах бичил үйлдвэр шинээр барьж байгуулж бренд бүтээгдэхүүн бий болгох.
- Малын тэжээлийн ургамлын тариалалтыг орон нутгийн иргэдийн оролцоотой нэмэгдүүлэх.
- Тариалан эрхлэгчид, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- Хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- Алим, жимс жимсгэнэ хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Улаанбаатар хот болон баруун аймгуудад Буянт сумын газар тариалан, МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг худалдан борлуулах түншлэлийг бий болгоно.
- Усалгаатай тариалан эрхлэх, техник, технологийн шинэчлэл хийх ажлыг санаачилна.
- Усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор хиймэл нуур, хөв цөөрөм байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачлагыг дэмжинэ.
- Нам даралтын зуухуудыг буулгаж, халаалтын нэгдсэн системд холбоно.
- Буянт голын бохирдлын асуудлыг шийдвэрлэж, Буянт голын ай савыг хамгаална.
- Орчноо ойжуулсан, цэцэрлэгжүүлсэн иргэд, айл өрхүүд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Сумын нийт нутаг дэвсгэрийн 50-аас доошгүй хувийг орон нутгийн тусгай хамгаалалтанд хамруулах бодлогыг хэрэгжүүлэх.
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, худаг, уст цэгүүд олноор гаргаж, булаг шандуудыг сэргээхэд анхаарч ажиллана.
- Тус сумын Нарийн гол багийн хадлангийн бүс нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, илүүдэл усны салааг боох ажилд идэвхи санаачлага гаргана.
- Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор замын хяналтын цэгүүд, камержуулалтыг бий болгох ажлыг санаачлах.



----oOo----